



2024 оон 04 сар 01 өдөр

Дугаар 12


Улаанбаатар хот

**Зээлийн шугамын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах,
Цагаан Алт хөтөлбөрийн эргэлтийн хөрөнгийн зээлийн гэрээ байгуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Говь” ХК нь “Хас Банк”-тай “Цагаан Алт хөтөлбөрийн эргэлтийн хөрөнгийн зээл”-ийн гэрээг дараах нөхцөлийн дагуу байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 1.1. Зээлийн хэмжээ: 60,000,000,000 (жаран тэрбум) төгрөг;
 - 1.2. Зээлийн хугацаа: 24 (хорин дөрвөн) сар;
 - 1.3. Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа: 6 (зургаан) сар;
 - 1.4. Төгрөгийн зээлийн хүү: жилийн 16.0 (арван зургаан) хувь, Засгийн газраас хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлт нь жилийн 10.0 (арван) хувь;
 - 1.5. Зээлийн гэрээний үүргийг хангуулахаар Хавсралт №1-д заасан “Говь” ХК-ийн бараа материалыг нэмэлтээр барьцаалах, Хавсралт №2-д заасан зээлийн шугамын гэрээнд барьцаатай үл хөдлөх хөрөнгүүдийг давхар барьцаалах.
2. “Хас Банк” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК, “Говь” ХК нарын 2024 оны 03-р сарын 15-ны өдөр байгуулсан ЗГ5005760266 тоот Зээлийн шугамын гэрээнд дээрх хөнгөлөлттэй зээлтэй холбоотойгоор дараах нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 2.1. Зээлийн шугамын эрхийг 31,300,000,000 (гучин нэгэн тэрбум гурван зуун сая) төгрөг болгон бууруулах;
 - 2.2. Хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтөөр зээлийн шугамын эрх 40,000,000,000 (дөчин тэрбум) төгрөг хүртэл буцан сэргэх;
 - 2.3. Зээлийн шугамын гэрээнд “Таван Богд Трейд” ХХК, “Жуулчин” ХХК, “Ю Би Пи” ХХК, “Улаанбаатар Гурил” ХХК-уудыг хамтран зээлдэгчээр нэмэх;
 - 2.4. Зээлийн шугамын гэрээнд барьцаатай Хавсралт №3-д заасан “Говь” ХК-ийн бараа материалыг барьцаанаас чөлөөлөх.
3. Зээлийн шугамын гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Хавсралт №4-д заасан “Говь” ХК-ийн хөрөнгүүдийг үргэлжлүүлэн барьцаалахыг зөвшөөрсүгэй.
4. Дээрх Зээлийн шугамын нэмэлт гэрээ, Хөнгөлөлттэй зээлийн гэрээ, Барьцааны гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил)-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН



2026 он 04 сар 01 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



[Signature]

Б.АМАРСАЙХАН

[Signature]

Д.ГЭРЭЛМАА

[Signature]

А.ЖАРГАЛМАА

[Signature]

Б.ОРГИЛ

[Signature]

Ц.ОРГИЛБОЛД

[Signature]

Д.ХУЛАН

[Signature]

Д.ХҮРЭЛБААТАР

[Signature]

Б.ЦЭЭНЯМ